

**6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

“А” вариант

- 1.Эхээ анхааралтай сайтар уншиж ойлгож дараах даалгаврыг гүйцэтгэх.
2. Тусдаа цаас гарган даалгаврыг гүйцэтгэх .

ГЭГЭЭРСЭН НЬ

Номч гэдэг нэртэй нэгэн өнчин ядуу хүү байжээ. Тэр сургуульд сурах хүсэлтэй ч зардал мөнгө хувцас... бүгд байхгүй бөгөөд бүх л өдөржин хар бор ажил хийж амиа тэжээдэг ажээ.

Тэр эрдэмд сурахын тулд идэх хоолныхоо мөнгөнөөс бага багаар цуглуулсаар ном авч эхэллээ. Ингэж бие даан суралцсаар удалгүй их эрдэм суран гэгээрч, баян хүн болжээ.

Ийнхүү ном гэдэг мэргэн багшийн ачаар ядуу хүү гэгээрч сайхан амьдралд хүрчээ.

1. Эхэд байгаа түлхүүр үгсийг зөв олсон хэсгийг дугуйлна уу \2 оноо

- | | |
|-----------------------------|-------------------|
| А. Ном, ядуу хүү, эрдэм ном | Б. Баян хүн, бага |
| багаар, хүрчээ | В. Хоол, ном, |
| сурах | |

**2. Өнчин хүү яаж эрдэм номд гэгээрч сайхан амьдралд хүрсэн бэ?
Холбогдолгүй хэсгийг олоорой . \2 оноо**

- А. Ном авсан Б. Бие даан суралцсан. В. Сургуульд сурах хүсэлгүй ч ном авсан.

3.Эрдэм гэдэг үгсийг 8 тийн ялгалын нөхцөлөөр хувилган бичих \2 оноо

.....
.....
.....
.....
.....

4.Дараах өгүүлбэрүүнийг өгүүлбэр гишүүдээр зурж , тодорхойлох. 2 оноо

Бат дээсээр тоглов.

Эмч нар вагоноор ирэв.

Дорж хөгжим тоглох дуртай .

Дүү нь бөмбөг тоглов.

5..Дараах үгсэд заахын тийн ялгалын нөхцөл залгаж бичихэд яаж зөв бичих

**6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

ЖИНЧИН ДАГАСАН МОГОЙ

Б вариант

Бээжин орохоор говийг туулан жинчид явж байжээ. Нэг өглөө ачаа барааных нь дэргэд нэг могой цагариглан хэвтэж байв. Хэн ч түүнийг сонирхож тоосонгүй. Маргааш нь нэг газар хоноод хөдлөхөд аанай л бас нөгөө могой хэвтэж байв. Хэн ч түүнийг анхаарч үзсэнгүй.

Тав дахь удаа хоноглоод хөдлөх гэж байтал элэг нь улаан нялга болчихсон хөөрхий могой мөлхсөөр орж ирлээ. Хөдлөх гэж байсан жинчид саатаж, тэмээгээ түр хэвтүүлэв. Могой яг л гурав дахь тэмээний хавьд очоод хэвтжээ.

- Энд л нэг учир байна даа гэхэд

- Наадах чинь эх могой байна.

Эцэст нь үр зулзагыг нь бид ачаандаа оруулсныг мэдсэн юм.

Нээрээ л тийм байжээ.

1. Аль нь эхийн сэдэв вэ? \2 оноо\

- А. Жинчдийн тухай
- Б. Эхийн сэтгэлийн тухай
- В. Эх могойн тухай
- Г. Жин тээсэн тухай

2. Эхийн гол санааг илэрхийлсэн хэлцийг олоорой. \ 2 оноо\

- А. Эхийн санаа үрд, үрийн санаа ууланд
- Б. Үхтэл үрийн төлөө
- В. Хүний эрээн дотроо, могойн эрээн гаднаа
- Г. Ачийг бачаар

3. Цаг хугацааг ямар үйл явдал болсныг эхээс олж бичих . 2 оноо

- 1. Эхлэл хэсэг
- 2. Нэг өглөө
- 3. Эцэст нь
- 4. Маргааш нь

4. Дараах үгсийг үгсийн аймагтай нь зөв харгалзуулаарай. \ 2 оноо \

- | | |
|------------|--------------------|
| А. Говь | 1. Орон цагийн нэр |
| Б. Маргааш | 2. Нэр үг |
| В. хөдлөх | 3. Нэр үг |
| Г. Бээжин | 4. Үйл үг |

5. Дараах үгсээс зөв бичсэн үгийг сонгон дугуйлаарай. \2оноо\

